

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн  
..... оны ..... дугаар сарын ..... -ний өдрийн  
..... дүгээр тогтоолын хавсралт

БАТЛАВ.  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ,  
ҮЙЛЧИЛГЭЭГ ХУДАЛДАН АВАГЧ:

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

ЭМДЕГ-ЫН ДАРГА

БАТЛАВ.  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ,  
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ:

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

ЭМБ-ЫН ДАРГА, ЗАХИРАЛ

### ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

202 ... оны ... дүгээр  
сарын ... -ны өдөр

Дугаар .....

.....хот/аймаг

Нэг талаас ..... регистрийн дугаартай ..... Эрүүл мэндийн байгууллага (цаашид “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч” гэх) нөгөө талаас Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (цаашид “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч”, хамтад нь “талууд” гэх) нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож, энэхүү гэрээг ..... жилийн хугацаатай байгуулав.

#### НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1. Энэхүү гэрээгээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн тусгай зөвшөөрөлд бичигдсэн үйл ажиллагааны хүрээнд Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.10-т заасан өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх зарим тусламж, үйлчилгээ, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-д заасан тусламж, үйлчилгээ, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хувьд тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.2, 9.1.13-т заасан, хүний эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд анагаах ухааны нотолгоонд суурилсан аргаар, чанартай, аюулгүй, шуурхай үзүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч нь иргэн-даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээг “чанарын болон төлбөр”-ийн хяналт, гүйцэтгэлд үндэслэн худалдан авахтай холбогдох харилцааг зохицуулна.

1.2. Талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын Захиргааны ерөнхий хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн

тусламж, үйлчилгээний тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталсан тогтоол, тушаал, журам, заавар болон энэхүү гэрээг дагаж мөрдөнө.

1.3. Дор дурдсан баримт бичиг нь энэхүү гэрээний салшгүй хэсэг (цаашид “гэрээний баримт бичиг” гэх) болно:

1.3.1. тусламж, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, төлбөрийн хэмжээг тогтоосон нэгдүгээр хавсралт;

1.3.2. гэрээг дүгнэхэд харгалзах тусламж, үйлчилгээний тоо болон чанарыг хэмжих шалгуур үзүүлэлт бүхий хоёрдугаар хавсралт;

1.3.3. талуудын харилцах сувгийг тодорхойлсон гуравдугаар хавсралт;

1.4. Талууд гэрээтэй холбоотой асуудлаар зөвхөн албан ёсны хүрээнд харилцах ба үүнд энэхүү гэрээний гуравдугаар хавсралтад тодорхойлсон харилцах сувгаар цаасан ба цахим хэлбэрээр илгээсэн албан бичиг, төлбөрийн нэхэмжлэл, түүнчлэн тэмдэглэлээр баталгаажсан уулзалт хамаарна.

## **ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ**

2.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч дараах эрх эдэлнэ:

2.1.1. иргэн, даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээнд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.6, 14.8.7-т заасан холбогдох журмын дагуу чанарын болон төлбөрийн хяналт хийх;

2.1.2. Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.10-т заасан өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх төлбөрийг нь төр хариуцах тусламж, үйлчилгээнд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн 80%-ийг сар бүрийн 11-ний дотор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид олгон, үлдэгдэл 20%-ийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн сар бүрийн гэрээний шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн үнэлгээнд үндэслэн олгох эсэхийг шийдвэрлэх;

2.1.3. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9, сум тосгоны эрүүл мэндийн төвийн хувьд 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.2, 9.1.13-т заасан тусламж, үйлчилгээний урьдчилгаа болгож, өмнөх сарын гүйцэтгэлийн 80 хүртэлх хувиар тооцон, урьдчилгаа санхүүжилтийг сар бүрийн 11-ний дотор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид олгох;

2.1.4. гэрээний 2.1.3-т заасны дагуу олгосон тусламж, үйлчилгээний зардлын урьдчилгаа төлбөр нь шаардлага хангасан нэхэмжлэлийн төлбөрийн дүнгээс давсан тохиолдолд зөрүүг дараа саруудын урьдчилгаа төлбөрөөс суутгах;

2.1.5. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой иргэн, хуулийн этгээдээс гаргасан гомдол, шүүхийн маргаан болон хяналтаар зөрчил илрүүлсэн тохиолдолд газар дээрх хяналт хийх, эмнэл зүйн аудит хийж,

шинжээчээр дүгнэлт гаргуулах зэрэг хяналтын үйл ажиллагаанаас холбогдох арга хэмжээг авах;

2.1.6. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, Зөрчлийн тухай хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг үйлдсэн гэж үзвэл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах;

2.1.7. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчээс холбогдох хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой баримт, мэдээллийг шаардаж гаргуулах;

2.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч дараах үүрэг хүлээнэ:

2.2.1. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчээс ирүүлсэн нэхэмжлэлийг хянаж, хяналтын үр дүнд суурилан шаардлага хангасан нэхэмжлэлийн төлбөрийн хэмжээг тогтоох;

2.2.2. гэрээний 2.2.1-т заасан тооцооны үр дүнд үндэслэн нэхэмжлэлийн хяналт дууссанаас хойш холбогдох журамд заасан хугацаанд багтаан тусламж, үйлчилгээний төлбөрийн урьдчилгаа болон гүйцэтгэлийн зөрүүг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх;

2.2.3. Хяналт дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан тайлан, дүгнэлтийг цахимаар хүргүүлэх:

2.2.3.1. төлбөрийн нэхэмжлэлийн хяналтын тайлан;

2.2.3.2. эрүүл мэндийн байгууллага дээр хийх хяналт, гэрээний хэрэгжилтийг хянасан тухай дүгнэлт;

2.2.3.3. эмнэл зүйн аудит хийсэн шинжээчийн дүгнэлт;

2.2.4. нэхэмжлэлийн хяналтын талаар болон албан тушаалтны ашиг сонирхлын зөрчил, ёс зүйн талаар гаргасан гомдлыг гомдол хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан хянан үзэж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид хариу хүргүүлэх;

2.2.5. тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын үр дүнд хагас, бүтэн жилээр дүн шинжилгээ хийж, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах талаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид зөвлөмж өгөх;

2.2.6. эрүүл мэндийн даатгалын цахим мэдээллийн сан, тусламж, үйлчилгээний чанар, зардлын төлбөрийн хяналттай холбоотой журам, шалгуур, аргачлал, удирдамж, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээллийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид тухай бүр хүргүүлэх;

2.2.7. хөнгөлөлттэй эмийн жор бичих эмчийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, программд нэвтрэх эрхийг цаг хугацаанд нь нээх;

2.2.8. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид эрүүл мэндийн даатгалын мэдээллийн цахим системд хандах техникийн боломжийг олгох, системийн хөгжүүлэлт, хэвийн ажиллагааг хангах, мэдээлэл дамжуулах загварыг гаргах;

### 2.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч дараах эрх эдэлнэ:

2.3.1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9, сум тосгоны эрүүл мэндийн төвийн хувьд 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.2, 9.1.13-т заасан тусламж, үйлчилгээний шаардлага хангасан нэхэмжлэлийн төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжлэх;

2.3.2. Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.10-т заасан өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх төлбөрийг нь төр хариуцах нэг иргэнээр тооцсон тусламж, үйлчилгээний санхүүжилтийг нэхэмжлэх;

2.3.3. тусламж, үйлчилгээний зардалд зориулж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчаас урьдчилгаа төлбөр нэхэмжлэх;

2.3.4. хяналтын тайлан, дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд тайлан, дүгнэлт хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт, эрүүл мэндийн даатгалтай холбоотой аливаа асуудлаар холбогдох тайлбар, гомдол, саналаа тусламж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчид албан бичгээр хүргүүлэх;

2.3.5. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч байгууллагын цахим мэдээллийн сангийн зөвшөөрөгдсөн хэсэгт нэвтрэх, холбогдох мэдээллийг хүсэх;

### 2.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч дараах үүрэг хүлээнэ:

2.4.1. үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг цахим системээр, нэхэмжлэлийг гэрээний баримт бичигт заасан цахим хаягаар сар бүрийн 5-ны дотор хүргүүлэх;

2.4.2. төсвийн тухай хуульд заасан санхүүгийн тайлангийн цаглабартай холбогдуулан тухайн төсвийн жилийн 6, 12 дугаар саруудад үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг тухайн сарын 10-ны өдрөөр тасалбар болгон хуанлийн 2 хоногт багтаан илгээх, 11-ний өдрөөс тухайн сар дуусталх хугацаанд үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг дараа сарын нэхэмжлэлтэй хамтатган эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчид хүргүүлэх;

2.4.3. даатгуулагчдад үзүүлсэн тусламж үйлчилгээний зардлын гүйцэтгэлийг тухайн төсвийн жилийн 7 дугаар сарын 10-ны өдрийн дотор, дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор тус тус тусламж үйлчилгээ худалдан авагч байгууллагатай тооцоо нийлэх;

2.4.4. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн хаяг, хуулийн этгээдийн нэр, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, эцсийн өмчлөгчийн мэдээлэлд өөрчлөлт орох тохиолдолд 10 ба түүнээс дээш хоногийн өмнө эрүүл мэндийн

тусламж, үйлчилгээг худалдан авагч байгууллагад албан бичгээр мэдэгдэж, гэрээний 4.1.4-т заасны дагуу өөрчлөлт оруулах;

2.4.5. нарийвчилсан хяналт хийхээр сонгосон тохиолдол бүрийн түүврийн жагсаалтыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авагч хүргүүлснээс хойш 8 цагийн дотор цахимаар холбогдох маягтуудын дагуу хүргүүлэх;

2.4.6. тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах зайлшгүй болон нэмэлт шаардлагыг гэрээний хугацаанд хангаж ажиллах. Хэрэв холбогдох шаардлагыг хангах боломжгүй болсон тохиолдолд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчид мэдэгдэж холбогдох арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлэх;

2.4.7. амь тэнссэн үеийн яаралтай тусламж шаардлагатай хүнд төлбөр шаардахгүйгээр эрүүл мэндийн даатгалаар тусламж, үйлчилгээ үзүүлэх;

2.4.8. иргэн, даатгуулагчаас журам, тогтоол, гэрээнд тусгаснаас өөр нэмэлт төлбөр авахгүй байх;

2.4.9. Гэрээнд тусгагдсан тоо хэмжээ дууссан гэх шалтгаанаар даатгалын сангаас санхүүжүүлдэг тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэхийг санал болгох, үзүүлэхээс татгалзах, нэмэлтээр албан бус төлбөр авахгүй байх;

2.4.10. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой хууль, тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт болон даатгалаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээ, түүний төлбөрийн мэдээлэл шинэчилэгдсэн тухай бүр иргэдэд ил тод мэдээлдэг байх;

2.4.11. иргэн, даатгуулагчид хөнгөлөлттэй олгох эмийн жор бичих;

2.4.12. хяналт шалгалт хийхэд шаардагдах баримт, нотолгоо, мэдээллийг тусламж, үйлчилгээ худалдан авагчид цаг хугацаанд нь саадгүй гаргаж өгөх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчийг хяналт шалгалт хийх нөхцөлөөр хангах;

2.4.13. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авагчид гаргаж өгсөн мэдээлэл болон иргэн, даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлын мэдээллийг цахим системээр үнэн, зөв, алдаагүй илгээх;

2.4.14. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчаас тогтоосон шаардлагад нийцүүлж цахим системээр мэдээлэл солилцох, техникийн боломж бүрдүүлэх, баталсан загварын дагуу цахимаар мэдээллийг тогтоосон хугацаанд ирүүлэх;

2.4.15. тусламж, үйлчилгээ үзүүлэгч өөрөө үзүүлэх боломжтой тусламж, үйлчилгээг бусад эрүүл мэндийн байгууллагад илгээж даатгуулагчийг төлбөр төлөх эрсдэлд оруулахгүй байх;

2.4.16. Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу ажилтнуудаа нийгмийн даатгалд бүрэн хамруулж, тайлан мэдээг нийгмийн даатгалын байгууллагад хуулийн хугацаанд ирүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлгагүй байх;

2.4.17. иргэн, даатгуулагчийн эрүүл мэндийн болон тусламж, үйлчилгээний мэдээллийн нууцлалыг хадгалах;

### ГУРАВ. ЧАНАР БОЛОН ТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ

3.1. Эрүүл мэндийн даатгалын сангаас болон даатгуулагчаас төлөх төлбөрийн хэмжээ, төлбөрийн аргыг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 14 дүгээр зүйлийн 14.9.8-д заасан холбогдох журмын дагуу хэрэгжүүлнэ.

3.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн хяналт нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.8.7, 16.1.5, 23.2.3-т тус тус заасныг хэрэгжүүлэх болон бусад холбогдох хуулийн хүрээнд явагдана.

3.3. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.6, 14.8.7, 14.9.8-д тус тус заасан холбогдох журмын шалгуурыг хангаагүй тусламж, үйлчилгээний тохиолдлын төлбөрийг санхүүжүүлэхгүй.

3.4. Гэрээний 4.2-т заасан шалтгаанаар гэрээг түдгэлзүүлэн шалгахад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн буруутай нь нотлогдсон тохиолдолд энэ хугацаанд харгалзах тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийг санхүүжүүлэхгүй.

3.5. гэрээний нэгдүгээр хавсралтаар баталсан, Эрүүл мэндийн даатгалын хуулийн 9.1.9-т заасан тусламж, үйлчилгээний тоо хэмжээнээс хэтэрсэн, даатгуулагчаас нэмэлт төлбөр авсан нэхэмжлэлийг санхүүжүүлэхгүй. нэхэмжлэл;

3.6. Гэрээний 2.4.1, 2.4.2-т заасан хугацаанд хүргүүлээгүй нэхэмжлэлийг хянах болон санхүүжүүлэхгүй.

3.7. Гэрээний 2.4.4-т эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч нь Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд заасан хаяг, байршлаас өөр хаяг байршилд үйлчилгээ үзүүлсэн тохиолдлын нэхэмжлэлийг санхүүжүүлэхгүй.

3.8. Гэрээний 2.4.5-д заасан хугацаанд хүргүүлээгүй түүврийн жагсаалтыг хянах болон санхүүжүүлэхгүй.

3.9. эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрөл эсхүл магадлан итгэмжлэлийн хугацаа нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр сунгагдахдаа уг хугацаа дуусгавар болсон өдрөөс нөхөж сунгагдсан тохиолдолд дээрх хугацаан дахь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9-т заасан тусламж, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлийг санхүүжүүлэхгүй;

### ДӨРӨВ. ГЭРЭЭНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ

4.1. Дараах тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулна:

4.1.1. гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд эрх бүхий этгээдээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөр (эрүүл мэндийн даатгалын

сан болон даатгуулагчийн төлбөр)-ийн хэмжээг өөрчлөх шийдвэр гаргасан бол;

4.1.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч энэхүү гэрээний Хавсралт 1-д нэмэлт сонгон шалгаруулалтын үр дүнгээр тэнцсэн тусламж, үйлчилгээний төрлөөр гэрээнд өөрчлөлт оруулах шийдвэр гарсан тохиолдолд;

4.1.3. Хуулийн этгээдийн хаяг, хуулийн этгээдийн нэр, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, эцсийн өмчлөгч өөрчилснийг эрх бүхий байгууллага бүртгэгдсэнийг үндэслэн;

4.1.4. Гэрээний агуулгын голлох ач холбогдол бүхий харилцаа тухайн гэрээг байгуулснаас хойш бүхэлдээ өөрчлөгдсөн, гэрээний аль нэг тал гэрээний анхны зохицуулалтыг цаашид баримтлах боломжгүй гэж үзсэн бол уг гэрээнд өөрчлөлт оруулахыг шаардах эрхтэй.

4.1.5. Энэхүү гэрээний 4.1.1-4.1.3-т заасан шийдвэр гарснаас ажлын 5 хоногийн дотор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч гэрээний холбогдох заалт, хавсралтад өөрчлөлт оруулах мэдэгдлийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлж, гэрээнд өөрчлөлт оруулах хэлцлийг эхлүүлнэ;

4.1.6. Талууд гэрээнд өөрчлөлт оруулах саналаа бичгээр гаргах бөгөөд санал гаргаснаас хойш нэг сарын дотор зөвшилцөл хийх ажлыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч зохион байгуулж нэмэлт гэрээ байгуулна.

4.1.7. Гэрээнд орсон өөрчлөлтийг талууд хүлээн зөвшөөрч, нэмэлт гэрээ байгуулж, гарын үсэг зурж, тамга тэмдэгээр баталгаажуулж, батлуулснаар гэрээний өөрчлөлт хүчин төгөлдөр болно.

4.1.8. хуульд заасан бусад үндэслэл.

4.2. Дараах тохиолдолд гэрээг түдгэлзүүлнэ:

4.2.1. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн магадлан итгэмжлэл, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд гэрээг бүхэлд нь;

4.2.2. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчээс ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэлийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч шалгах явцад эмнэлгийн алдаа, зөрчил илэрч, дахин нягтлан шалгах шаардлага гарсан тохиолдолд гэрээний баримт бичгийн холбогдох хэсгийг;

4.2.3. эрх бүхий этгээдээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг нь хэсэгчлэн болон бүхэлд нь зогсоох шийдвэр гаргасан бол гэрээг бүхэлд нь эсхүл гэрээний баримт бичгийн холбогдох хэсгийг;

4.2.4. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч гэрээг бүхэлд нь эсхүл гэрээний холбогдох баримт бичгийн тодорхой хэсгийг түр түдгэлзүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд;

4.2.5. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчаас газар дээр нь хийсэн хяналт шалгалтаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч сонгон шалгаруулалтаар шаардсан тусгай шаардлагыг хангаагүй, эсхүл хуурамчаар бичиг баримт бүрдүүлж, гэрээнд заасан шаардлагыг хангаагүй нь тогтоогдсон бол гэрээг бүхэлд нь эсхүл гэрээний баримт бичгийн холбогдох хэсгийг;

4.2.6. иргэн, даатгуулагчид хөнгөлөлттэй үнээр эм олгох жор бичих нөхцөл, шаардлагыг хангаагүй тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9-т заасан тусламж, үйлчилгээг үзүүлэх, худалдан авахтай холбоотой гэрээний баримт бичгийн холбогдох хэсгийг;

4.2.7. гэрээний 2.4.4-д заасны дагуу өөрчлөлт орсон мэдээллийг хугацаанд нь мэдэгдээгүй;

4.2.8. гэрээний 2.4.12, 2.4.13, 2.4.14-д тус тус заасан тогтоосон шаардлага, хугацаа, батлагдсан загварын дагуу мэдээлэл ирүүлээгүй;

4.2.9. Гэрээний 2.4.15-д заасны дагуу үйл ажиллгаагаа явуулаагүй;

4.2.10. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээ, үйл ажиллагаа, төлбөрийн нэхэмжлэлтэй холбоотой зөрчил илэрснийг шалгаж эхэлсэнээр;

4.2.11. Тусламж, үйлчилгээ худалдан авагч болон тусламж, үйлчилгээ үзүүлэгч нарын хууль болон гэрээгээр хүлээсэн үүрэгтэй холбоотойгоор шүүхийн хянан шийдвэрлэх маргаан үүссэнээр;

4.3. Дараах тохиолдолд нотлох баримтад үндэслэн гэрээг бүхэлд нь эсхүл гэрээний баримт бичгийн холбогдох хэсгийг түдгэлзүүлснийг цуцлах эсэхийг шийдвэрлэнэ:

4.3.1. энэхүү гэрээний 4.2.1-3.2.6-т заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн шалтгааныг шийдвэрлэсэн тухай мэдэгдлийг ирүүлснээс хойш ажлын 10 хоногийн дотор;

4.3.2. энэхүү гэрээний 4.2.7-4.2.11-д заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн шалтгааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай мэдэгдлийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчид ирүүлснээс хойш 30 хоногийн дотор.

4.4. Дараах тохиолдолд гэрээний Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-тэй холбогдох тусламж, үйлчилгээг үзүүлэх, худалдан авахтай холбогдох харилцааг хугацаанаас нь өмнө цуцлах үндэслэл болно:

4.4.1. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч гэрээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн 70 буюу түүнээс дээш хувийг хангаагүй бол;



4.4.2. дараах зөрчлийн тохиолдол нийлбэр дүнгээрээ тухайн хугацаанд ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэлийн тоо хэмжээний эсхүл мөнгөн дүнгийн 10 хувьд хүрсэн бол:

- 4.4.2.1. хуурамч нэхэмжлэл илгээсэн;
- 4.4.2.2. завших оролдлого хийсэн;
- 4.4.2.3. оношийн код ахиулж нэхэмжилсэн.

4.4.3. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч гэрээг түр түдгэлзүүлсэн хугацаанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчаас тавьсан шаардлагыг тогтоосон хугацаанд хангаагүй бол;

4.4.4. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчийн зүгээс хийх хяналт шалгалтад саад учруулсан, хяналт шалгалтаас зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, зайлсхийсэн, хяналт шалгалтад нөлөөлөхийг оролдсон, хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийг арилгаагүй, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, дахин давтан зөрчил гаргасан нь нотлогдсон;

4.4.5. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч нь тус гэрээг байгуулж хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойш 3 сарын хугацаанд иргэн даатгуулагчдад тусламж, үйлчилгээ үзүүлээгүй;

4.4.6. гэрээг өөрчлөх боломжгүй, эсхүл гэрээний аль нэг тал өөрчлөлт оруулахгүй гэж үзвэл;

4.4.7. Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан зөрчлийг удаа дараа гаргасан;

4.4.8. гэрээг хуулийн этгээдийг төлөөлөх эрхгүй этгээд байгуулсан;

4.4.9. гэрээний 6.1-т заасан хугацаанд гэрээ дүгнүүлээгүй;

4.5. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч гэрээг цуцлах шийдвэр гаргаснаас хойш ажлын 5 хоногийн дотор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид шийдвэрийг албан бичгээр хүргүүлнэ.

4.6. Талууд гэрээг харилцан тохиролцсоны үндсэн дээр цуцалж болно.

4.7. Хууль, журамд заасан бусад үндэслэл.

## **ТАВ. ХАРИУЦЛАГА**

5.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч гэрээний үүргийг биелүүлээгүй нь тогтоогдвол дараах хариуцлага хүлээнэ:

5.1.1. энэхүү гэрээний 2.1.2, 2.1.3-т заасан төлбөрийг хугацаанаас хожимдуулж төлсөн тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн мөнгөн дүнгээс дараах хувь хэмжээгээр тооцож эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид алданги төлнө:

5.1.1.1. гүйцэтгээгүй үүргийн мөнгөн дүн 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөг ба түүнээс их бол нэхэмжилсэн үнийн дүнгийн 0.05 хувиар;

5.1.1.2. гүйцэтгээгүй үүргийн мөнгөн дүн 500,000,000 (таван зуун сая) төгрөгөөс 1,000,000,000 (нэг тэрбум) хүртэл төгрөг бол нэхэмжилсэн үнийн дүнгийн 0.1 хувиар;

5.1.1.3. гүйцэтгээгүй үүргийн мөнгөн дүн 500,000,000 (таван зуун сая) төгрөг хүртэл бол нэхэмжилсэн үнийн дүнгийн 0.2 хувиар.

5.1.2. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээний нууцлалыг хангаагүй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.2. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч гэрээний үүргийг биелүүлээгүй нь тогтоогдвол дараах хариуцлага хүлээнэ:

5.2.1. энэхүү гэрээний 4.2-т заасан үндэслэлээр гэрээг түр түдгэлзүүлэхээс өмнөх хугацаанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагчаас төлсөн төлбөрийг нөхөн суутгана. Нөхөн суутгах графикийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч тогтоох бөгөөд төлбөр нь графикт хугацаанаас хэтэрсэн тохиолдолд нөхөн төлөх төлбөрийн дүнгээс хэтэрсэн хоног тутамд 0.1 хувьтай тэнцэх алданги тооцох;

5.2.2. энэхүү гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд хоцроосон хоног тутамд холбогдох тусламж, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлийн дүнгийн 0.5 хувиар тооцож суутгах;

5.2.3. эмнэл зүйн аудитын дүгнэлтээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн буруутай нь нотлогдсон тохиолдолд тухайн тусламж, үйлчилгээний төлбөрийг нөхөн суутгах;

5.2.4. иргэн хариуцан төлөх төлбөрөөс өөр төлбөрийг иргэнээс авсан тохиолдолд иргэнээс авсан нэмэлт төлбөрийн нэхэмжлэлтэй дүйцэх санхүүжилтийг дараагийн санхүүжилтээс бууруулах, Зөрчлийн тухай хуулийн дагуу торгууль оногдуулах;

5.2.5. хөнгөлөлттэй эмийн жор бичих эрхгүй эмчээр жор бичүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад холбогдох хууль, журмын дагуу торгууль оногдуулах;

5.2.6. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтны буруугаас даатгуулагчид учирсан хохирлыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага хариуцна;

5.2.7. гэрээний 4.4-т заасан үндэслэлээр талуудын хооронд байгуулсан гэрээ цуцлагдсан тохиолдолд тухайн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч дараагийн нэгдсэн сонгон шалгаруулалт зарлагдаж, тэнцэх хүртэл хугацаанд гэрээ байгуулах эрхгүй;

5.3. гэрээний 4.1, 4.2, 4.3, 4.4-д заасан нь үндэслэлээр Эрүүл мэндийн даатгалын цахим системд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчийн нэвтрэх эрхийг нээж, хаана.

5.4. Хууль, журамд заасан бусад хариуцлага;

### **ЗУРГАА. ГЭРЭЭГ ДҮГНЭХ**

6.1. Энэхүү гэрээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, эрх бүхий этгээдээс баталсан гэрээ дүгнэх аргачлал, журмын дагуу дараа оны 12 дугаар сарын 01-ны дотор дүгнэнэ.

6.2. Гэрээний хэрэгжилтийн явц, үр дүнгийн үнэлгээний тайланг эрүүл мэндийн даатгалын байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлнэ.

6.3. Гэрээний хэрэгжилтийн үр дүнг үндэслэн, 90 хувь ба түүнээс дээш оноогоор үнэлэгдсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.10-т заасан өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх төлбөрийг нь төр хариуцах тусламж, үйлчилгээнд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн үлдэгдэл болох 20 хувийг гэрээ дүгнэснээс хойш ажлын 10 хоногийн дотор олгоно.

### **ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

7.1. Энэхүү гэрээтэй холбоотой талуудын хооронд үүссэн аливаа маргааныг дараах арга замаар шийдвэрлэнэ:

7.1.1. гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг талууд эв зүйгээр шийдвэрлэнэ;

7.1.2. нэхэмжлэл, чанар, төлбөрийн хяналттай холбогдох маргааныг холбогдох журмын дагуу;

7.1.3. тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналттай холбоотой маргааныг талуудаас гаргасан нотолгоонд үндэслэн хөндлөнгийн шинжээчийн дүгнэлтээр;

7.1.4. Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, Зөрчлийн тухай хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг Зөрчил шалган шийдвэрлэх хуулийн дагуу;

7.1.4. маргааныг хэлэлцээр хийж шийдвэрлэхээр бичгээр хүсэлт гаргавал Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу;

7.1.5. хэрэв талууд маргааныг эцэслэн шийдэрлүүлж чадаагүй бол Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлүүлэх;

7.2. Талууд энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргаан шийдвэрлэхэд зөвхөн албан бичгээр харилцсан харилцааг баримт, нотолгоо болгоно.

7.3. Гэрээ, гэрээний баримт бичигтэй холбогдох аливаа маргаан болон гэрээнд өөрчлөлт оруулах, хэлэлцээр хийх зэрэг гэрээний аливаа харилцаанд талууд өөрсдөө төлөөлөн оролцох бөгөөд уг харилцаанд гуравдагч талыг оролцуулахгүй.

## **НАЙМ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ**

8.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсоноо нотолсон тохиолдолд гэрээний хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болно.

8.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжийг гэрчлэхэд дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ:

8.2.1. Гал түймэр болон байгалийн гамшиг болох үер, ган, зуд, аюултай цасан болон шороон шуурга, газар хөдлөлт;

8.2.2. Нийтийг хамарсан аюулт халдварт өвчний улмаас хорио цээр тогтоосон бүсэд хоригдсон болон дайчилгаанд хамрагдсан зэрэг нөхцөл байдал;

8.2.3. Тэсрэлт, дэлбэрэлт, машин, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн эвдрэл, цахилгааны ноцтой гэмтэл;

8.2.4. Төрийн албан тушаалтны хуулийн дагуух болон хууль бус үйлдэл, эс үйлдэл, эрх зүйн акт, тушаал, захирамж, ажлын байр татан буугдах, эд хөрөнгө дайчлан хураах, нийгэмчлэх зэрэг саад тотгор тохиолдсон үед;

Тайлбар: Энэхүү гэрээний 8.2-т заасан шинжийг агуулсан хүчин зүйлсээс үүдэлтэй гэрээний аль нэг тал үүргээ гүйцэтгээгүй нь түүний хяналтаас гадна орших саад бэрхшээлээс болсон бөгөөд гэрээ байгуулах үед уг саад бэрхшээлийг тооцох, түүнээс зайлсхийх буюу түүний үр дагаврыг нь давж гарах арга замыг урьдчилан тооцох аргагүй байсныг дээрх тал тус тус нотолбол тухайн тал үүрэг гүйцэтгээгүйн хариуцлагыг хүлээхгүй бөгөөд хүндэтгэн үзэх шалгаан гэж ойлгоно.

## **ЕС. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ**

9.1. Энэхүү гэрээ болон гэрээний баримт бичиг нь талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

9.2. Гэрээг 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгална.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ,  
ҮЙЛЧИЛГЭЭГ ХУДАЛДАН АВАГЧИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:

(Албан тушаал, нэр)

(Гарын үсэг) \_\_\_\_\_

ТАМГА

(Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг  
худалдан авагчийн хаяг)

(Утас, факсын дугаар)

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ,  
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:

(Албан тушаал, нэр)

(Гарын үсэг) \_\_\_\_\_

ТАМГА

(Тусламж, эрүүл мэндийн тусламж,  
үйлчилгээ үзүүлэгчийн хаяг)

(Утас, факсын дугаар)

(Харилцагч банкны нэр, дансны  
дугаар)